

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 03 сарын 21-ны өдөр

Дугаар

БА-096/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 2 давхар 1 блок, 150 (нэг зуун тавь) ор бүхий хүчин чадалтай цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

**Хоёр. Ерөнхий мэдээлэл**

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024/04/24, 2025/02/12, огноо, 00014852 БА32024/0233, 0002060 БА32025/005 дугаар,

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: MSL-23-06


2.3. Захиалагч: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар оноосон нэр, 9014001040 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5369622 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 дугаар хороо, Арцатын аманд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны нэгдсэн цогцолбор барилга "Б" блок 5 давхар 510 тоот, 11311632 холбоо барих утас;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Ванхүү ХХК оноосон нэр, 9011175124 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2588552 регистрийн дугаар, БУ19-905/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэотэй дүүрэг, 14 дүгээр хороо, Хайлаастын 1-1 тоот, 11357102 холбоо барих утас;

2.5. Барилгын ажлын туслан гүйцэтгэгч: Байхгүй.

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Эм Эс Эл ХХК оноосон нэр, 9011573077 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6021026 регистрийн дугаар, ЗТ12-245/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 43 дугаар хороо, Ub tower 1503 тоот, 75330088 холбоо барих утас;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Нийслэлийн 248 дугаар цэцэрлэг оноосон нэр, 000147201 Улсын бүртгэлийн гэрчилгээний



дугаар, 6208738 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 13 дугаар хороо, 99158814 холбоо барих утас, Kindergarden\_@ebub цахим хаяг;

## 2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

### Гурав. Дүгнэлтийн хэсэг

#### ✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

#### □ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 2 давхар 1 блок, 150 (нэг зуун тавь) ор бүхий хүчин чадалтай цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

#### 3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

ХЯНАЛТ ШАЛГА  
ГАЗАР

Барилга байгууламжийг  
оруулах коми

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

#### Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Дунд төвөгшилтэй ангиллын зорьтой 2 давхар 1 блок, 150 (нэг зуун тавь) ор бүхий хүчин чадалтай цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо,  
Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газрын захиалгатай,  
зорьтой 2 давхар 1 блок, 150 (нэг зуун тавь) ортой цэцэрлэгийн барилга

Комиссын дарга:  
Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:  
Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын газрын  
Барилга захиалагчийн хэлтсийн дарга




(Б.Ганзориг)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



МЭДЭЭЛЛИЙН СААД БҮРТГЭЭ.  
Объектын дугаар: 715  
Огноо: 2015.08.21 сар, 21 өдөр  
Бүртгэсэн  
УЛААНБААТАР ХОТ УТ 11.1584



ЛТЫН  
ашиглалтанд  
эс

СҮХБААТАР ДҮҮРГИЙН 13 ДУГААР ХОРОО, НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 2 ДАВХАР 1 БЛОК, 150 (НЭГ  
ЗУУН ТАВЬ) ОРТОЙ ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ  
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 24

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зорьтой 2 давхар 1 блок, 150 ортой цэцэрлэгийн барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1 дүгээр давхрын танхимд 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр 13:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 15:00 цагт дуусав.

Хуралд:

- |                                                                                                                                          |                         |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч | А.Мөнгөн                |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Барилга захиалагчийн хэлтсийн хяналтын инженер                    | С.Ууганцэцэг            |
| 3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч               | Б.Шинэжаргал            |
| 4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч                                  | Э.Цогзолмаа<br>Ж.Энхзул |
| 5. 248 дугаар цэцэрлэгийн эрхлэгч                                                                                                        |                         |
| 6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК<br>Техник хяналтын инженер                                                                   | Ц.Наранцацрал           |
| 7. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК,<br>Технологийн удирдлага төлөвлөлтийн газрын Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн                       | Н.Даваадэмид            |
| 8. Ус сувгийн удирдах газар Хэрэглэгчдэд үйлчлэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер                                         | Б.Жалбалцанжид          |
| 9. Нийслэлийн Онцгой байдлын газар, Барилгын зураг төслийн хяналтын ахлах байцаагч, Хошууч                                               | Б.Дөл-Эрдэнэ            |
| 10. Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын архивч                                                                            | Н.Өлзийжаргал           |
| 11. Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер                                                    | О.Ундрах                |

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтад  
оруулах комисс

12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан	Б.Даваасүрэн
13. Хэсэгчилсэн инженер шугам сүлжээний газар Сэлбэ дулааны станцын инженер	Н.Оюунбат
14. Ванхүү ХХК-ийн захирал	Б.Боролзойхүү
15. Зураг төсөл зохиогч, Эм эс эл ХХК-ийн архитектор	Л.Сумъяажав

#### ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зорьтой 2 давхар 1 блок, 150 (нэг зуун тавь) ортой цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

#### СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч **Б.Шинэжаргал:**

- Барилгад ашигласан материалын тохирлын гэрчилгээ, ил далд ажлын акт, улаан журнал, тусгай зөвшөөрөл, бетоны бат бэхийн шинжилгээний бичиг, үе шат бүрээр, БАЗГ үзүүлэх;
- Ашиглагч 248 дугаар цэцэрлэгийн эрхлэгчид тус барилга байгууламжтай холбоотой бичиг баримтыг 1% акт үйлдэж хүлээлцэх;
- БТХ-ийн 14.3, 14.6 заалтыг дагуу чанарын баталгаа албан тоот ирүүлэх;
- Халаах хэрэгсэлд хүүхдүүд бэртэхээс сэргийлсэн хамгаалалт хийх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандарт хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа:**

- Гадна ДХ-т батлагдсан зурагт 4 лүк төлөвлөсөн ба одоо угсрагдсанаар 2 лүк байгааг зохиогч тайлбар албан тоот ирүүлэх;
- ДХ-т цэвэрлэгээ хийж, шугам сүлжээг өнгийн туузаар ороож, шатны байрлалыг стандартын түвшинд бэхлэх;
- Холигч насосын узелийг хаягжуулах, контролёрыг хананд бэхлэх;
- Анги танхимын халаах хэрэгсэлүүд дээр хаалт хамгаалах хэрэгсэл хийж фото зургаар баталгаажуулах;
- Дээвэр дээрх АС-н шахтнаас бохирын хоолойг өндөрлөж, малгайвч хийх;
- Дотор халаалтын системийг угсарсан сорилтын актыг бүрэн баталгаажуулах;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер  
**Ц.Наранцацрал:**

- 01/01778/24 Техникийн нөхцөлийн дагуу холбогдсон (100кВА-400кВА) залгах зөвшөөрөл;
- 0,4 кВ кабелийн ил далд ажлын акт, фото акт;
- ТН-ийн 4,6 дахь заалт дизель генераторыг ДА-нд бүртгүүлж, харъяа ашиглалт засварын төвтэй шуурхай ашиглагааны гэрээ хийх;
- Дэд өртөөний гүйдэлийн трансформаторыг ХҮТ-өөр лацдуулах;
- Гадна гэрэлтүүлгийн ил далд ажлын актыг нөхөж бүртгүүлэх, урлаг заалны разетикт хамгаалалт хийх;
- Газар чөлөөлсөн айл өрхийн ЦЭХ-д хангах гэрээг цуглуулсан баримт, барилга баригдах усны төлбөр тооцоогүй байх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Технологийн удирдлага төлөвлөлтийн газрын  
Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Даваадэмид:**

- Зоорийн давхарт холбооны техникийн өрөө болон кабель шугамын тавиур бирк зүүн хаягжуулах;
- Гадна холбооны акт бичиг баримтын бүрдлийг хангах;
- Гадна холбооны ШХ-1 худагт таг хүзүү суурилуулан доторх хог шороог гаргаж цэвэрлэх;
- Гадна холбооны ШХ-2 худаг дахь шороог авч цэвэрлэх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн менежер  
**Б.Жалбалцанжид:**

- Гадна бохир усны шугамын ажлын зурагт өөрчлөлт орсныг зургийн авторын тайлбар албан бичиг өгөх, бохир усны худгуудад шат суурилуулах ажлын талбайг янзлах;
- Гүйцэтгэлийн зураг болон хотын мэдээллийн санд өгсөн актыг шалгуулах; (хуучин 248-р цэцэрлэгийн цэвэр усны шугам өртөгсөнг)

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Нийслэлийн Онцгой байдлын газар, Барилгын зураг төслийн хяналтын ахлах  
байцаагч, Хошууч **Б.Дөл-Эрдэнэ:**

- Гал түймэр унтраах хоолой. Техникийн шаардлага MNS65-76:2016 стандартын дагуу гал түймэр унтраах хоолой хошууны тотго, хомут солих /Балтанов тотго/;
- Гал түймэр унтраах анхан шатны багаж зэвсэглэмж гал унтраагуур байрлуулах;
- Аврах зам гарцын тэмдэг тэмдэглэгээг хийх;
- Гадна дулаалгын ажлын ил далд ажлын акт, фото зураг, материалын шинжилгээний дүгнэлт нөхөж үзүүлэх;

- Аваарын гарц шатны тавцан, шатны марш хүчитгэх (дэр кавдрат, угольник хийх);
- Гал унтраах авто машины орц гарц төлөвлөх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивын эрхлэгч **Н.Өлзийжаргал:**

- Зураг төсөл боловсруулах гэрээ гэрчилгээ, тусгай зөвшөөрөл; зохиогчийн гэрээ, магадлал хийх гэрээ, усны шинжилгээ, захиалагчийн дүгнэлт, чанарын баталгааг хувийн хэрэгт хавсаргах;
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийг гүйцэтгэгч байгууллагаар баталгаажуулах;
- Ил далд ажлын акт, гэрэл зураг, материалын сертификатыг бүрэн бүрдүүлэх;
- Баримт бичгийн хуудас дугаарлаж дотоод товъёг үйлдэх;
- Ажлын зураг болон холбогдох баримтын эх хувийг архивт хүлээлгэн өгөх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, Барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн инженер **О.Ундрах :**

- Цоколын давхарт цонхны хамгаалалтын ирмэг буланг засаж аюулгүй байдлыг хангах;
- Коридорын шилэн фасадтай хэсгүүдэд хамгаалалтын хайс хийх;
- Гэрээ байгуулсан төсвийн хүрээнд норм нормативын төлбөр төлөх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Даваасүрэн:**

- Гадна урд авто машины зогсоолд ХБИ-ний авто машинд зориулсан зогсоолыг стандартын дагуу төлөвлөж хийх (босоо тэмдэглэгээтэй);
- Үүдний налуу замд 2 талдаа ижил бариул хийх;
- Явган хүний замуудад авто зогсоолоос явган замруу, шинэ замаас хуучин явган замруу замуудыг стандартын дагуу хийх;
- Урлаг заалны тайзруу налуу замыг стандартын дагуу хийх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Ашиглагч байгуулга, 248-р цэцэрлэгийн эрхлэгч **Ж.Энхзул:**

- 2 цэцэрлэгийг хооронд нь холбож хаалга гаргах;
- Бүлгүүдийн пааранд хамгаалалт хийх;
- Дээд давхрын тоглоомын талбайн шатыг стандартын дагуу хийх;
- Тоглоомын талбайд ус зайлуулах хоолой хийх;
- Цэцэрлэгийн хашааг дуусгаж өгөх;
- Тогдоомын талбайг бэхэлгээг сайн хийх;

ЛТ ШАЛ  
ГАЗА

гууламжи  
руулах ко

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна

Зураг төсөл зохиогч Эм Эс Эл ХХК-ийн архитектор **Л.Сумъяажав**:

- Агаар сэлгэлтийн системийн цэвэрлэгээ, битүүмж хийх;
- Малгайвчыг дээшлүүлэх;
- Улаан дэвтэрийн сүүлийн бичилтийг хангуулах;
- Оруулах системийн хоолойг агаар халаагч хүртэл дулаалах;
- Гадна дулааны худгын тагийг дулаалах;
- Узелын хаягжуулалт хийх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Сэлбэ дулааны станц, дулааны инженер **Н.Оюунбат**:

- Гүйцэтгэлийн зураг мэдээлэлийн сангийн акт шалгуулах;
- Гүйцэтгэлийн баримт бичиг 1% өгөх;
- ДХ- н шат будах;
- Холигч насосын узелийн хаягжуулалт хийх;
- Гадна дулааны шугамын далд ажлын акт үзүүлэх;

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна.

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын хяналтын инженер **С.Ууганцэцэг**:

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авах саналтай байна

Ванхүү ХХК-ийн захирал **Б.Боролзойхүү** :

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **А.Мөнгөн**:

- БТХ-ын дагуу гүйцэтгэгч чанарын баталгаа албан бичгээр ирүүлэх;
- Дээврийн /ашиглалтай/ тоглоомын талбайг ногоон зүлэг , төмөр хашлагны доод боолт бэхэлгээг сайжруулах, хамгаалах аюулгүй байдал хангах;
- В1 давхрын шилэн хаалтны хатаалттай шилний шинжилгээний бичиг ирүүлэх;
- Гадна хашааны зэврэлтээс хамгаалах таг, хамгаалалт хийх;

АЛТЫН  
г ашиглалт  
ИСС

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгатай, зоорьтой 2 давхар 1 блок, 150 (нэг зуун тавь) ортой цэцэрлэгийн өргөтгөл барилгыг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын,  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч



..... (А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар,  
Барилга захиалагчийн хэлтсийн дарга



..... (Б.Ганзориг)